



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1/37

Ханх сум

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/324 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах (зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар болон санал авах байранд), хяналтын тооллого хийхтэй холбогдуулан сумын нутаг дэвсгэрт 2024 оны 06 дугаар сарын 27, 28, 29-ний өдрийг дуустал хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг, 06 дугаар сарын 28-ны өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг тус тус хориглосугай.

2. Тус өдрүүдэд дээрх төрлийн үйл ажиллагаа явуулахгүй байхыг төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийг олон нийтэд сурталчилж, мэдээлэх хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг ажиллахыг Цагдаагийн тасаг (АХМА), Б.Мөнхтөр)-д даалгасугай.

ДАРГА Л. ДАВААБАЯР

